

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: **ХӨДӨЛМӨРИЙН ЭРХ ЗҮЙ СУДЛААЧДЫН ХОЛБОО**

Төслийн нэр: **“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 67 дугаар зүйлд хийх мониторинг”**

Төслийн баг:

1. Төслийн удирдагч Л.Баасан

Хууль зүйн шинжлэх ухааны доктор(Sc.D),Отгонтэнгэр их сургуулийн дэд захирал

2. Төслийн менежер Б.Уранцэцэг

Хууль зүйн ухааны доктор(Ph.D), Удирдлагын академийн багш

3. Төслийн ажилтан С.Гэрэлмаа

Хууль зүйн ухааны магистр, Хууль Зүйн Үндэсний Төвийн”Төрийн байгуулалт, хууль тогтоомжийн сектор”-ын эрхлэгч

4. Төслийн ажилтан С.Болормаа

Хууль зүйн ухааны докторант, МУИС-ийн Хууль Зүйн Сургуулийн Иргэний Эрх Зүйн тэнхимийн багш

Төслийн үндсэн зорилго: “Ажлаас үндэслэлгүй халагдсан, өөр ажилд буруу шилжсэн ажилтныг ажилд нь эгүүлэн тогтоох тухай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн холбогдох заалтад хийгдэх мониторингийн үйл ажиллагаа нь 2003 оны 4-р улирлаас 2006 оны эхний 3 улирлын хугацаанд Нийслэлийн хэмжээний 6 дүүргийн шүүхээс гаргасан агуулга бүхий Шүүхийн шийдвэрүүдийн биелэлт бодитой хангагдаж ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтнууд, төрийн албан хаагчид өмнөх буюу хуучин ажил , албан тушаалдаа орж буй эсэх,Шүүхийн шийдвэрийг биелүүлэх талаар Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба хэрхэн ажиллаж байгаа, ажилтны ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг нь гаргуулж чадаж буй эсэх, ажилтныг өмнөх ажилд нь эргүүлэн тогтоож , улсад учруулсан хохирлыг буруутай этгээдээр бүрэн төлүүлж байгаад зохих судалгаа хийхэд энэхүү төслийн зорилго оршино.

Мөн дээрх шалтгаан нөхцлийн улмаас шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг биелүүлэхгүй байгаагаас улсын төсөвт ямар хохирол учруулж байгаа (учир нь шүүхийн шийдвэр гарах, түүнийг биелүүлэх бүх л үйл ажиллагааны зардал нь улсын төсвөөс буюу татвар төлөгчдийн төлсөн татварын мөнгөөр явагддаг ба шийдвэр биелэгдэхгүй байгаа нь эргээд татвар төлөгчдийн төлсөн татварын мөнгө ямар ч үр ашиггүй зарцуулагдаж байгаа хэрэг болно), талаар тодорхой нэг дүүргийн шүүх дээр судалгаа хийн шүүхийн шийдвэр хэрэгжилтэнд саад болж буй шалтгаануудыг арилгах арга замын талаар зохих саналыг боловсруулж энэ талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх,мөн практикийн байгууллагуудын төлөөллийг оролцуулсан семинар, бага хурал зохион байгуулах, хууль тогтоох болон шүүх, шийдвэр гүйцэтгэлийн байгууллагын зохих албан тушаалтанд хандсан зөвлөмж гаргах болно.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬ (2002 он)

67.2 Үндэслэлгүйгээр ажлаас халагдсан буюу өөр ажилд шилжүүлсэн ажилтныг урьдах ажил, албан тушаалд нь эгүүлэн тогтоох тухай шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй бол шийдвэр гүйцэтгэгч албадан гүйцэтгэх тухай мэдэгдлийг хариуцагчид хүргүүлнэ.

67.3 Мэдэгдлийг хүлээн авсан хариуцагч урьд гаргасан шийдвэрээ хүчингүй болгож, тухайн ажилтныг урьдах ажилд нь эгүүлэн тогтоосноор шийдвэр биелэгдсэнд тооцно.

67.4 Энэ хуулийн 67.2, 67.3-т заасан **шаардлагыг** хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй бол шийдвэр гүйцэтгэгч ажилтны ажилгүй байсан хугацааны цалин, хөдөлмөрийн хөлс буюу бага цалин, хөдөлмөрийн хөлстэй ажил хийж байсны зөрүүг шийдвэр гарсан өдрөөс түүнийг **гүйцэтгэх өдөр хүртэл** хугацаанд шийдвэр гүйцэтгээгүй **буруутай албан тушаалтнаас албадан гаргуулах** арга хэмжээ авна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дээрх заалтууд нь Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хуулийн 69-р зүйлийн 69.1, болон Эрүүгийн хуулийн 258-р зүйлийн 258.1-тэй харилцан уялдаатай хэрэглэгдэх учир тус мониторингод эдгээр хуулийн холбогдох заалтуудад мөн мониторинг хийсэн болно.

Хөдөлмөрийн тухай хууль(1999 он)

69.1 Энэ хуулийн 36.1.2-т заасны дагуу ажилтныг ажил, албан тушаалд нь эгүүлэн тогтоосон бол түүнд ажилгүй байсан **бүх хугацаанд нь** урьд авч байсан дундаж цалин хөлстэй тэнцэх олговор, хэрэв бага цалинтай ажил хийж байсан бол зөрүүтэй тэнцэх **олговор олгоно.**

Эрүүгийн хууль(2002 он)

258.1 хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийтгэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг санаатай биелүүлээгүй , эсхүл биелүүлэхэд нь зориуд саад учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

МОНИТОРИНГИЙН АРГАЧЛАЛ

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн холбогдох заалт хэрэгжиж байгаа эсэхэд мониторинг хийхдээ дараахь аргачлалын дагуу хийнэ.

1. Ажлаас үндэслэлгүй халагдсан, өөр ажилд буруу шилжүүлсэн иргэнийг ажилд нь эгүүлэн тогтоох шийдвэрийн хэрэгжилтийг зохицуулж буй хууль тогтоомж, эрх зүйн актын судалгаа хийх (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүгийн хууль болон холбогдох бусад хууль эрхийн актууд)
2. Төрийн албан хаагчийг ажилд нь эгүүлэн тогтоосон шүүхийн шийдвэрийн статистик судалгаа хийх (Шүүхийн архивын 2003 оноос 2006 оны 1-3р улирлыг хүртэлх материалтай танилцан судалгаа хийн түүвэрлэх)
3. Төрийн албан хаагч үндэслэлгүйгээр ажлаас халагдсан тухай Төрийн албаны зөвлөлд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдлыг судлах (2003 оноос 2006 оны 1-3р улирлыг хүртэлх материалтай танилцан судалгаа хийн түүвэрлэх)
4. Төрийн албан хаагчийг ажилд нь эгүүлэн тогтоосон шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаагаас эрх нь зөрчигдөн эрхэлж байгаа ажил албан тушаалдаа орж чадахгүй байгаа иргэний талаар бодит баримт, мэдээдэл цуглуулах (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2003 оноос 2006 оны 3-р улирлыг хүртэлх хугацааны материалтай танилцан судалгаа хийн түүвэрлэх)
5. Цуглуулсан мэдээ баримтандаа үндэслэн зохих шинжилгээ бүхий дүгнэлт гаргах
6. Ажилд нь эгүүлэн тогтоосон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон боловч төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас эрхэлж байсан ажил албан тушаалдаа намын харьяалал, улс төрийн шалтгаанаар эргэн орж чадахгүй байгаа иргэдтэй ярилцага хийх, бодит байдалтай танилцах, холбогдох материалтай танилцах , бусад байгууллалатай хамтран ажиллах (Хүний Эрхийн Үндэсний Комисс болон бусад)
7. Дээрх шалтгаан нөхцлийн улмаас төрийн албан хаагчийг ажилд нь эгүүлэн авахгүй байгаа бодит тохиолдолд газар дээр нь очиж судлах
8. Ажилтанд ажилгүй байсан хугацааны цалин олгосноос байгууллагад учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар бүрэн төлүүлж байгаа эсэхийг шүүхийн шийдвэрийг үндэслэн судлах
9. Эрүүгийн хуулийн 258-р зүйлийн дагуу хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй гэм буруутай албан тушаалтанд

эрүүгийн хэрэг үүсгэж шалгасан эсэх талаар Нийслэлийн Цагдаагийн
Газрын архивын материалтай танилцах

10.Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа
нөхцөл шалтгааны талаар Нийслэлийн шүүхийн шийдвэр
гүйцэтгэгчдээс анкетын асуулга авах

ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА